



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/82

Булган сум

“Аймгийн 2024 оны тэргүүний Ахмад настан”,
шилдэг “Ахмадын хороо”,
“Ахмадыг дэмжигч байгууллага”-ыг шагнах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Оны тэргүүний Ахмад настан, шилдэг Ахмадын хороо, шилдэг Ахмадыг дэмжигч байгууллага шалгаруулах журмыг шинэчлэн батлах тухай” ХХ/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 онд ахмад настануудын нийгмийн хамгааллыг сайжруулж, хөгжил оролцоог дэмжих чиглэлээр идэвх зүтгэл гарган, бүтээлчээр ажиллаж, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан тэргүүний “Ахмад настан”, шилдэг “Ахмадын хороо”, “Ахмадыг дэмжигч байгууллага”-ыг хавсралтаар баталж, шагнасугай.

2. Оны шилдэг иргэн, байгууллагыг шагнахад шаардагдах 3,250,000 (гурван сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Шагнал гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулж, шагнагдсан иргэн, байгууллагуудыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан, алдаршуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг), аймгийн Ахмадын хорооны дарга (Б.Ширчиндорж) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010139

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 17-ны/ний өдрийн ... 4/27 дүгээр
захирамжийн хавсралт

Аймгийн оны тэргүүний "Ахмад настан", шилдэг "Ахмадын хороо",
"Ахмадад ээлтэй байгууллага"-аар шалгарсан иргэн,
байгууллага хамт олонд олгох шагнал

д/д	Шалгарсан төрөл	Оны шилдэг иргэн, байгууллага	Өргөмжлөл	Шагналын зардал	Нийт зардал
1	2	3	4	5	6
1	Оны тэргүүний "Ахмад настан"	Хутаг-Өндөр сумын 1-р багийн иргэн О.Бааст	50,000	500,000	550,000
2	Оны шилдэг "Ахмадын хороо"	Хишиг-Өндөр сумын "Ахмадын хороо"	50,000	500,000	550,000
3	Оны шилдэг "Ахмадын хороо"	Тэшиг сумын "Ахмадын хороо"	50,000	500,000	550,000
4	Оны шилдэг "Ахмадын хороо"	Баян-Агт сумын "Ахмадын хороо"	50,000	500,000	550,000
5	Оны шилдэг "Ахмадыг дэмжигч байгууллага"	Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	50,000	300,000	350,000
6	Оны шилдэг "Ахмадыг дэмжигч байгууллага"	Хишиг-Өндөр сумын "Дөрвөн хөвгүүд" ХХК	50,000	300,000	350,000
7	Оны шилдэг "Ахмадыг дэмжигч байгууллага"	Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	50,000	300,000	350,000
Нийт дүн		3,250,000			